



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА  
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ховд аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2022/10/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Ховд хот

2023 он

Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 70432545

Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn

Ахлах аудитор: Ц.Гантулга

Утас: 99439613

цахим хаяг: Oyunjargals@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

<b>1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ</b> .....	<b>Error! Bookmark not defined.</b>
<b>2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ</b> .....	<b>5</b>
<b>3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА</b> .....	<b>11</b>
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	12
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	13
<b>3.5.1 Төсвийн төлөвлөлт</b> .....	<b>13</b>
<b>3.5.2 Төсвийн гүйцэтгэл</b> .....	<b>13</b>
<b>3.5.3 Нэмэлт төсөв</b> .....	<b>13</b>
<b>4. АУДИТЫН ТАЙЛАН</b> .....	<b>13</b>
<b>4.1 Ерөнхий зүйл</b> .....	<b>13</b>
<b>4.2 Материаллаг байдал</b> .....	<b>14</b>
<b>4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт</b> .....	<b>14</b>
<b>4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал</b> .....	<b>14</b>
<b>4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт</b> .....	<b>14</b>
<b>4.5 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн</b> .....	<b>14</b>
<b>5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ</b> .....	<b>14</b>

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТШЗ	Төсвийн шууд захирагч

---



**ХОВД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**  
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд  
Утас: 976-70433061, Факс: 976-70433061  
E-mail: khovd@audit.gov.mn

УЛСЫН БҮРТГЭЛИЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА  
С.ХОРОЛСҮРЭН ТАНАА

2023.02.24 № 02/88  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ховд аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Ховд аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 47.8 сая төгрөгийн тоног төхөөрөмж шилжүүлэн авсан байна.

### Аудитын гол асуудал

Монгол улсын Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоолоор “үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг” шинэчлэн тогтоосон, цалинд өөрчлөлт орж цалингийн шатлал нэмэгдсэн байна.

### Бусад асуудлын хэсэг

2022 онд 4 зорилт 27 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулан батлуулж, биелэлтийг тооцон төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлжээ.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

021020286

## Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:



Х.БОЛДБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/ төгрөгөөр /

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>53,003,919.81</u></b>	<b><u>66,658,757.51</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	562,994.30	803,350.00
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	562,994.30	803,350.00
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	562,994.30	803,350.00
31213	Арилжааны банк дахь харилцах	562,994.30	803,350.00
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	00.00	19,968,000.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	00.00	19,968,000.00
3351	Байгууллагаас авах авлага	00.00	19,968,000.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	52,440,925.51	45,887,407.51
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	11,705,626.80	13,400,108.80
35110	Тусгай зориулалттай материал	11,705,626.80	13,400,108.80
35300	Бэлэн бүтээгдэхүүн	4,151,190.00	8,533,420.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	36,584,108.71	23,953,878.71
35410	Бичиг хэргийн материал	2,235,500.00	535,400.00
35420	Аж ахуйн материал	34,348,608.71	23,338,478.71
35470	Бусад хангамжийн материал	00.00	80,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>173,964,837.99</u></b>	<b><u>164,556,343.81</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	173,964,837.99	164,556,343.81
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	173,964,837.99	164,556,343.81
39203	Авто-тээврийн хэрэгсэл	14,100,000.00	14,100,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-7,050,000.00	-9,870,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	292,329,527.65	328,631,163.65
39206	Хуримтлагдсан элэгдэл	-133,171,900.18	-172,691,730.56
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	43,619,970.00	43,619,970.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-35,862,759.48	-39,233,059.28
39301	Програм хангамж	5,419,900.00	5,419,900.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-5,419,900.00	-5,419,900.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>226,968,757.80</u></b>	<b><u>231,215,101.32</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>562,994.30</u></b>	<b><u>803,350.00</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	562,994.30	803,350.00
<b>414</b>	<b>Урьдчилж орсон орлого</b>	562,994.30	803,350.00
41410	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	562,994.30	803,350.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>226,405,763.50</u></b>	<b><u>230,411,751.32</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	226,405,763.50	230,411,751.32
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	226,405,763.50	230,411,751.32
51210	Өмнөх үеийн үр дүн	226,405,763.50	226,405,763.50
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	4,005,987.82
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>226,968,757.80</u></b>	<b><u>231,215,101.32</u></b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>853,978,340.00</b>	<b>609,125,822.03</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>219,259,340.00</b>	<b>47,873,722.03</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	219,259,340.00	47,873,722.03
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	219,259,340.00	47,873,722.03
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	219,259,340.00	47,873,722.03
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>634,719,000.00</b>	<b>561,252,100.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	545,867,500.00	556,252,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	545,867,500.00	556,252,100.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	88,851,500.00	5,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	5,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	88,851,500.00	00.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>717,649,721.83</b>	<b>597,719,834.21</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>717,649,721.83</b>	<b>597,719,834.21</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	717,294,521.83	592,898,675.12
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	458,687,474.00	445,061,474.00
210101	Үндсэн цалин	415,979,529.23	404,812,255.00
210102	Нэмэгдэл	37,558,749.00	35,889,919.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,149,195.77	4,359,300.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	59,014,169.91	55,353,719.54
210201	Тэтгэврийн даатгал	48,821,566.75	46,227,120.06
210202	Тэтгэмжийн даатгал	2,644,378.99	2,306,006.15
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,115,504.74	1,760,964.81
210204	Ажилгүйдлийн даатгал	493,883.53	429,848.14
210205	Эрүүл мэндийн даатгал	4,938,835.90	4,629,780.38
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	13,546,900.00	9,381,000.00
210301	Гэрэл, цахилгаан	291,200.00	191,200.00
210302	Түлш, халаалт	3,047,700.00	1,982,800.00
210303	Цэвэр, бохир ус	208,000.00	136,600.00
210304	Байрны түрээс	10,000,000.00	7,070,400.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	20,888,735.00	28,095,377.37
210401	Бичиг хэрэг	10,014,200.00	11,998,900.00
210402	Тээвэр, шатахуун	5,325,600.00	2,982,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,025,979.14	1,333,447.37
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	77,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,522,955.86	3,792,200.00
210408	Бараа материал актгалсны зардал	00.00	7,911,330.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	33,830,600.00	2,073,100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	172,600.00	904,200.00
210602	Тавилга	00.00	00.00

210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	32,426,300.00	200,000.00
210604	Урсгал засвар	1,231,700.00	968,900.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>24,334,610.41</b>	<b>8,390,098.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	231,000.00	1,285,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	280,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	106,905.86	100,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	83,615.00	48,700.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	00.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	23,611,089.55	6,955,598.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>106,992,032.51</b>	<b>44,543,906.21</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	88,851,500.00	00.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	28,644.14	374,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	18,111,888.37	44,169,906.21
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>355,200.00</b>	<b>4,821,159.09</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>355,200.00</b>	<b>512,500.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	355,200.00	512,500.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>00.00</b>	<b>4,308,659.09</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	4,308,659.09
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>136,328,618.17</u></b>	<b><u>11,405,987.82</u></b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>00.00</b>	<b>7,400,000.00</b>
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	00.00	7,400,000.00
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>00.00</b>	<b>-7,400,000.00</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>136,328,618.17</u></b>	<b><u>4,005,987.82</u></b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>850,912,555.86</u></b>	<b><u>703,427,102.05</u></b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b><u>216,193,555.86</u></b>	<b><u>142,175,002.05</u></b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	216,193,555.86	142,175,002.05
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	216,193,555.86	142,175,002.05
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	216,193,555.86	142,175,002.05
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b><u>634,719,000.00</u></b>	<b><u>561,252,100.00</u></b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	545,867,500.00	556,252,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	545,867,500.00	556,252,100.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>88,851,500.00</b>	<b>5,000,000.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	5,000,000.00

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	88,851,500.00	00.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>850,349,561.56</b>	<b>703,186,746.35</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>850,349,561.56</b>	<b>703,186,746.35</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>634,363,800.00</b>	<b>556,430,940.91</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	442,849,400.00	444,807,893.54
210101	Үндсэн цалин	372,082,972.00	357,999,847.12
210102	Нэмэгдэл	60,876,328.92	67,733,758.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,890,099.08	8,706,500.00
210104	Урамшуулал	00.00	10,367,788.42
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	69,447,500.00	55,607,300.00
210201	Тэтгэврийн даатгал	51,959,500.00	37,812,900.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,372,000.00	4,448,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,497,600.00	3,558,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	874,400.00	889,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	8,744,000.00	8,897,200.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	13,546,900.00	9,381,000.00
210301	Гэрэл, цахилгаан	291,200.00	191,200.00
210302	Түлш, халаалт	3,047,700.00	1,982,800.00
210303	Цэвэр, бохир ус	208,000.00	136,600.00
210304	Байрны түрээс	10,000,000.00	7,070,400.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	14,845,200.00	15,921,347.37
210401	Бичиг хэрэг	5,608,800.00	8,933,300.00
210402	Тээвэр, шатахуун	5,487,600.00	2,982,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,976,500.00	1,333,447.37
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	42,500.00	31,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,729,800.00	2,640,600.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	2,838,300.00	22,897,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	863,300.00	22,123,200.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	566,700.00	552,800.00
210604	Урсгал засвар	1,408,300.00	221,400.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	1,023,000.00	7,154,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	481,000.00	7,005,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	280,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	120,000.00	100,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	120,000.00	48,700.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,000.00	00.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	89,813,500.00	661,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	88,851,500.00	00.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	962,000.00	661,500.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>215,985,761.56</b>	<b>146,755,805.44</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	355,200.00	512,500.00

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	355,200.00	512,500.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>215,630,561.56</b>	<b>146,243,305.44</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	4,308,659.09
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>562,994.30</b>	<b>240,355.70</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	562,994.30	240,355.70
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	562,994.30
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	562,994.30	803,350.00

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2021 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл	00.00	00.00	87,919,954.99	87,919,954.99
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	<b>00.00</b>	<b>00.00</b>	<b>87,919,954.99</b>	87,919,954.99
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	8,675,341.93	8,675,341.93
C08	2021 оны 12-р сарын 31- ээрх үлдэгдэл	<b>00.00</b>	<b>00.00</b>	<b>226,405,763.50</b>	226,405,763.50
D01	2021 оны 12-р сарын 31- ээрх үлдэгдэл	<b>00.00</b>	<b>00.00</b>	<b>226,405,763.50</b>	226,405,763.50
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	<b>00.00</b>	<b>00.00</b>	<b>226,405,763.50</b>	226,405,763.50
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	4,005,987.82	4,005,987.82
D09	2022 оны 12-р сарын 31- ээрх үлдэгдэл	<b>00.00</b>	<b>00.00</b>	<b>230,411,751.32</b>	230,411,751.32

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>1</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	556,252,100.00	551,943,440.91
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	556,252,100.00	551,943,440.91
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	555,079,500.00	551,430,940.91
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	444,858,000.00	444,807,893.54
210101	Үндсэн цалин	371,957,700.00	357,999,847.12
210102	Нэмэгдэл	62,076,300.00	67,733,758.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	10,824,000.00	8,706,500.00
210104	Урамшуулал	00.00	10,367,788.42
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	55,607,300.00	55,607,300.00
210201	Тэтгэврийн даатгал	37,812,900.00	37,812,900.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,448,600.00	4,448,600.00
210203	ҮОМШО-ний даатгал	3,558,900.00	3,558,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	889,700.00	889,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	8,897,200.00	8,897,200.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	9,381,000.00	9,381,000.00
210301	Гэрэл, цахилгаан	191,200.00	191,200.00
210302	Түлш, халаалт	1,982,800.00	1,982,800.00
210303	Цэвэр, бохир ус	136,600.00	136,600.00
210304	Байрны түрээс	7,070,400.00	7,070,400.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	17,861,100.00	15,921,347.37
210401	Бичиг хэрэг	8,933,300.00	8,933,300.00
210402	Тээвэр, шатахуун	2,982,500.00	2,982,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,442,000.00	1,333,447.37
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	50,700.00	31,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,452,600.00	2,640,600.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	23,834,400.00	22,897,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	22,402,900.00	22,123,200.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	891,700.00	552,800.00
210604	Урсгал засвар	539,800.00	221,400.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	2,705,500.00	2,154,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,268,500.00	2,005,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	235,400.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	100,800.00	100,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	100,800.00	48,700.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	832,200.00	661,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	832,200.00	661,500.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	1,172,600.00	512,500.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	1,172,600.00	512,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,172,600.00	512,500.00

	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	556,252,100.00	552,922,349.86
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	556,252,100.00	552,922,349.86
131001	Улсын төсвөөс санхүүжих	556,252,100.00	552,922,349.86
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	00.00	562,994.30
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	00.00	803,350.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	41.00	41.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	32.00	32.00
620003	Үйлчлэх ажилтан	04.00	04.00
620004	Гэрээт ажилтан	04.00	04.00

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Ховд аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс нь 2022 онд Улсын бүртгэлийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлж, иргэний, хуулийн этгээдийн, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйл ажиллагааг цахим болгох техник, тоног төхөөрөмж, программ хангамжийг сайжруулах гэсэн зорилт дэвшүүлэн 4 алба 41 албан хаагчтайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Тус байгууллага нь Хөдөлмөрийн тухай хууль, НББ тухай хууль, Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Иргэний улсын бүртгэлийн тухай хууль, Эд хөрөнгийн Эрхийн улсын бүртгэлийн тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх Төрийн хэмнэлтийн тухай хууль баталж мөрдөж эхэлсэн байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Байгууллагын даргын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг тус байгууллагын өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавин ажиллаж байна.

2022 онд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 02 дугаар 22-ны өдрийн 64 дүгээр тогтоолын дагуу Улсын бүртгэлийн хэлтсийн даргын 2022 оны 05 дугаар сарын 23-ны А/05 дугаар тушаалаар төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг, тооллогын ажлыг зохион байгуулах ажлын хэсэг 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр томилж, тооллогыг зохион байгуулж хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, бүрэн бүтэн байдалд хяналт тавих ажлуудыг зохион байгуулсан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Ховд аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Ховд аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс нь 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 4.3 сая төгрөгөөр буюу 1.9 хувиар өссөн байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая. төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	0	19.9	19.9
Бараа материал	52.4	45.9	(6.5)
Үндсэн хөрөнгө	173.9	164.5	(9.4)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>226.9</b>	<b>231.2</b>	<b>4.3</b>
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	226.4	230.4	4.0
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>226.9</b>	<b>231.2</b>	<b>4.3</b>

Дээрх хүснэгтээс харахад Ховд аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 4.3 сая төгрөгөөр өссөний материаллаг нөлөө нь мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгийн данстай холбоотой байна.

Дансны үлдэгдэлд гарсан дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- ✓ Авлагын данс 19.9 сая төгрөгөөр өссөн нь Архивын нягтаршуулсан шүүгээ худалдаж авсан ба гэрээний хугацаанд нийлүүлж чадаагүйтэй холбоотой байна.
- ✓ Бараа материалын данс 6.5 сая төгрөгөөр буурсан нь үндсэн хөрөнгийн данс руу бараа материал шилжүүлсэнтэй холбоотой байна.
- ✓ Үндсэн хөрөнгө 9.4 сая төгрөгөөр буурсан нь үндсэн хөрөнгийн элэгдлийн зардалтай холбоотой байна.
- ✓ Цэвэр хөрөнгө 4.3 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 556.3 сая, төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэн батлагдсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд улсын төсвөөс 556.3 сая, үндсэн үйл ажиллагааны орлого 142.1 сая, төгрөг гүйцэтгэлээр санхүүжиж 698.9 сая төгрөгийг зориулалтын дагуу зарцуулж 4.3 сая төгрөгийн төсвийг хэмнэж, улсын төсөвт 141.9 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 547.7 сая төгрөг 99.2 хувьтай байна.

#### Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Код	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	/сая төгрөг/
					Биелэлт
80101	Үндсэн үйл ажиллагаа	552.0	547.7	4.3	99.2%
	<b>дүн</b>	<b>552.0</b>	<b>547.7</b>	<b>4.3</b>	<b>99.2%</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан Хөшөөт хөгжил сангийн хөрөнгө оруулалтын 5 сая төгрөгийн төсвийг хэлтсийн зарцуулсан байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Ховд аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитор Ц.Гантулга 2023 оны 02 дугаар сарын 15-ний өдрөөс 02 дүгээр сарын 20-ны хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 22 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

#### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны орлого үр дүнгийн тайлангийн нийт зардлын 597.7 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 8.9 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 7.2 сая төгрөгөөр тогтоосон.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

*Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага хуулиар хориглосон зардлуудыг санхүүжүүлээгүй байна.*

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим системд таван саяас дээш орлогын гүйлгээг мэдээлээгүй, байсныг аудитын явцад залруулан мэдээлүүлээ.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### **4.5 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх аудитаар Байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримтдаа бензиний зөвшөөрөл олгох бичгийг тусган албажуулж нягтлан бодогч, нярав нарын хяналтаар олгож хэвших гэсэн зөвлөмж өгснийг хэрэгжүүлэн ажилласан байна.

### **5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

Аудитаар байгууллагын ирүүлсэн санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй, цалинтай холбоотой 07 сая төгрөгийн зөрчил илэрлээ.

## 5.1 Зөвлөмж

### 5.1.1 Цалингийн зардалтай холбоотой асуудал

**Илрүүлэлт:** Засаг даргын захирамжаар байгууллагын даргад үндсэн цалингаас урамшуулал олгох байтал сарын цалингаас олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5. -д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" гэсэн заалтыг зөрчсөн байна.

**Зөвлөмж:** Зөрүүтэй тооцож олгосон 699167 төгрөгийг 2023 оны 3 сарын 30-ны дотор суутган тооцох.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/ сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуц ага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Цалингийн суутгал хийх	1	0.7					1	0.7	-	-	-	-
Дүн	1	0.7					1	0.7			-	-

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:  Х.БОЛДБААТАР

АУДИТЫН МЕНЕЖЕР:  А.ЦЭЦЭГСҮРЭН

ТАЙЛАНГ БИЧСЭН:

АУДИТОР

Ц.ГАНТУЛГА

